

**НУБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР  
2024 ОН**

<b>№</b>	<b>Төсөл, хөтөлбөрийн нэр</b>	<b>Хамрах хүрээ</b>	<b>Хэрэгжүүлсэн хугацаа</b>	<b>Хэрэгжүүлсэн байдал</b>
1	Стрептококкийн ангина, фарингит, хэрэх өвчин, хэрэхийн шалтгаант зүрхний олдмөл гажгийг эрт оношлох чадавхи олгох" сургалт зохион байгуулах удирдамж	Улсын хэмжээнд	2024.03.14 – 2024.03.15	Хүүхдэд тохиолдох А бүлгийн β-стрептококкийн гаралтай ангина, фарингит, хүүхдийн хэрэх өвчний оногшилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт мөн хэрэхийн шалтгаант зүрхний олдмөл гажгийн оношилгоо, эмчилгээний заавар, зөвлөмжийн хүрээнд 21 аймгаас Үндэсний сургач багш бэлтгэх сургалт зохион байгуулсан.
2	Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах удирдамж	Нийслэлийн хүрээнд	2024.03.27 - 2024.06.11	ЭМХТ-ийн захирлын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/35 тушаалын нэгдүгээр хавсралтаар Эрүүл мэндийн магадлан шинжлэх шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг 50 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан ажилласан. - Шалгуурын дэд бүлгүүдийг шинжээчидтэй хамтран шүүлт хийж эхний ээлжинд давхардсан утгатай шалгуур үзүүлэлтүүдийг хасах, нэгтгэх, өөрчлөх үйл ажиллагаанууд хийгдсэн. - Зөвлөхтэй хамтран ажлын хэсгийн гишүүдэд шалгуурын шинэчлэлийн арга зүйн сургалтыг зохион байгуулсан. - Олон улсын магадлан итгэмжлэлийн стандарттай харьцуулан шалгуурын шинэчлэлийг хийх ажил хийсэн. - Магадлан итгэмжлэлийн шинжээчдийг бэлтгэх чадавхжуулах зорилгоор ЭМХТ-ийн захирлын баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр "Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээчдийг чадавхжуулах нь" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.